



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/193

Бат-Өлзий сум

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5,6 дугаар заалт, Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох тухай” А/518 дугаар тушаал, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр 13-ны өдрийн А/450 дугаар тушаалын заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хуш модны самрыг бэлтгэх тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар, үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хуш модны самрын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх, тээвэрлэх хуш модны самрын тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдааг, 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнаж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, сум дундын Ойн ангийн дарга (Д.Очирхуяг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН